

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

**НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**

2026 он

Агуулга

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ.....	3
ХОЁР. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ.....	3
ГУРАВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ	5
3.1. Оролцогчдын гүйцэтгэх үүргийг тогтоох	6
3.2.Нэг бүрийн зардлыг тооцох.....	6
3.3.Тоон үзүүлэлтийг тооцох.....	9
3.4.Нийт зардлын мөнгөн дүнг тооцож гаргах	11
3.5. Хялбарчлах боломж байгаа эсэхийг тогтоох.....	12
3.6.Нэмэлт зардал	13
3.7.Дүгнэлт	13
ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ.....	14
4.1 Төрийн байгууллагын чиг, үүргийг тодорхойлох	14
4.2 Гарах зардлыг тооцох.....	26
4.3. Хувилбарыг нягталж зардлыг буулах боломжийг эрэлхийлэх	31
ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ.....	31

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардал, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцож, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан гаргав.

Аргачлалд заасны дагуу хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдсэн болно.

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаа авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11-д үндэслэн 2025 онд батлагдсан “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын заалтуудад хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан тооцоог нарийвчлах шаардлагатай хэсгүүдийг нэмэлтээр авч үзсэн болно.

ХОЁР. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хуулийн төсөлд эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээнд хяналт тавих, цахим орчны аюулгүй хэрэглээний мэдлэг олгох, шаардлагатай тохиолдолд насны ангилал болон технологи, зохион байгуулалтын хязгаарлалт хэрэглэх зэрэг үүргийг шинээр хүлээлгэж байгаа нь иргэнд тодорхой хэмжээний цаг хугацаа болон мөнгөн зардал үүсгэхээр байна.

Түүнчлэн хүүхдийн насыг баталгаажуулах зорилгоор хүүхэд бүрт “үүрэн холбооны хүүхдийн дугаар” олгох зохицуулалт хэрэгжихээр байгаа бөгөөд хүүхдийн нэр дээр гар утасны дугаар авах, ашиглахтай холбоотой зардал иргэн, өрхөд үүсэхээр байна.

Хүснэгт №1. Үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хүүхдийн дугаарын үнийн судалгаа /төгрөгөөр/

Үүрэн холбооны	Хүүхдийн дугаарын	Нэг удаагийн	Сарын
----------------	-------------------	--------------	-------

оператор	төрөл/үйлчилгээ	үнэ	үйлчилгээний төлбөр
Мобиком	0-13 насны хүүхэд “Star”, 14-с дээш насны хүүхэд “Be” дугаар ашигладаг	3,000	0
Юнител	Хүүхдийн дугаар гэж байхгүй, урьдчилсан төлбөрт дугаар гэж байгаа	3,000	3,000
Скайтел	“Alpha Kids” хүүхдийн дугаарыг 5-12 насны хүүхэд ашигладаг, 13-с дээш насны хүүхэд энгийн урьдчилсан төлбөрт дугаар ашиглана	5,000	7,000
Жи мобайл	0-18 насны хүүхэд “Enjoy kids” дугаар ашигладаг	5,000	5,000
Ондо	Насанд хүрээгүй хүнд дугаар зардаггүй, зөвхөн насанд хүрсэн хүн өөрийн бүртгэлээр дугаар авч хүүхэддээ ашиглуулах боломжтой		
Дундаж үнэ		4,000	3,750

Монгол Улсын хэмжээнд 2025 оны байдлаар 13–16 насны нийт 270,464 хүүхэд байна.

Хүснэгт №2. Монгол Улсад оршин суугаа 13-16 насны хүүхэд, насны ангиллаар

Хүүхдийн нас	2025 онд бүртгэгдсэн хүүхдийн тоо
13	72,613
14	68,908
15	62,681
16	66,262
Нийт дүн	270,464

Дээрх судалгаанаас харахад “үүрэн холбооны хүүхдийн дугаар” аваад зогсохгүй, цаашид тухайн дугаарыг хадгалах, ашиглахтай холбоотойгоор сар бүр үйлчилгээний төлбөр төлөх шаардлага үүсэхээр байна.

Хүснэгт 3. Зардлын задаргаа /төгрөгөөр/

Ангилал	Тоон үзүүлэлт
---------	---------------

13–16 насны хүүхдийн нийт тоо	270,464
Хүүхдийн дугаарын нэг удаагийн дундаж үнэ	4000
Хүүхдийн дугаарын сарын үйлчилгээний дундаж төлбөр	3750
Дугаар авах нийт зардал	1,081,856,000
Сарын нийт зардал	1,014,240,000
Жилийн нийт зардал	12,170,880,000

Түүнчлэн тухайн үүрэн холбооны хүүхдийн дугаарыг нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай холбох, насны ангилал баталгаажуулах, бүртгэл шинэчлэх зэрэг ажиллагаа нь иргэдэд нэмэлт цаг хугацааны болон технологийн ачаалал үүсгэнэ. Ялангуяа нэг өрх хүүхдийн тооноос хамаарч хүүхэд тус бүрд дугаар авах шаардлага бий болох бөгөөд ингэснээр өрхийн зардал нэмэгдэхээр байна. Нэг хүүхдэд үүсэх зардал жилд дунджаар 45,000 төгрөг байна.

Мөн хуулийн төслийн 9.2.5-д заасны дагуу эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь эцэг эхийн хяналтын хэрэгслийг ашиглаж хүүхдийн нийгмийн сүлжээний эрсдэлээс хамгаалах, 9.2.1-д заасан хүүхдийн ашиглаж буй нийгмийн сүлжээний үйлчилгээний талаар мэдлэгтэй байх, цахим ур чадвараа дээшлүүлэх сургалт, зөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагаас авах үүргийн хүрээнд иргэнд үүсэх нэмэлт зардалд эцэг эхийн хяналтын программ хангамжийг татаж, сургалтад хамрагдах зэрэг нэмэлт зардлыг тооцвол нэг өрхөд ногдох жилийн нэмэлт зардал дунджаар 15,000–25,000 төгрөг байж болохоор байна. Иймд хуулийн төсөлд батлагдсанаар иргэнд 60,000 – 70,000 төгрөгийн зардал үүсэж болохоор байна.

ГУРАВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Энэ хэсэгт хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан Аргачлалын 2.1-д заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- нэг бүрийн зардлыг тооцох;
- тоон үзүүлэлтийг тооцох;
- нийт зардлын дүнг тооцож гаргах;
- хялбарчлах боломжийг шалгах;
- нэмэлт зардлыг тооцох.

3.1. Оролцогчдын гүйцэтгэх үүргийг тогтоох

Энэхүү хуулийн төслийн хүрээнд “хуулийн этгээд” гэдэгт хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэн гэрчилгээ авсан, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг ойлгох бөгөөд түүнд хүлээлгэсэн үүрэгтэй холбоотойгоор үүсэх зардлыг тооцсон болно.

Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч байгууллагууд нь Монгол Улсад бүртгэлгүй хуулийн этгээд тул зардлыг тооцох боломжгүй байна.

Хуулийн төслийн 12.1-т заасан хуулийн этгээд нь дараах үүргийг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

1. Хэрэглэгчийн нас баталгаажуулах систем хөгжүүлэх
2. нас баталгаажуулах үйл явц, хүний хувийн мэдээллийн нууцлалыг хангах үйл ажиллагааны талаар хэрэглэгчийг шаардлагатай мэдээллээр хангах;
3. Хүүхдэд хориглосон агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлах технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх;
4. Хүүхдийн дугаар олгох;

3.2.Нэг бүрийн зардлыг тооцох

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд хуулийн этгээдээс зарцуулах хугацааг мөнгөн дүнгээр илэрхийлж гаргана. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. Үүрэг гүйцэтгэхэд шаардагдах стандарт үйл ажиллагааг тодорхойлох;
2. Үйл ажиллагаа тус бүрд зарцуулах хугацааг тодорхойлох;
3. Ажлын хөлсийг тодорхойлох.

Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Аргачлалд заасан хугацааг харгалзан үзэж, бусад ижил төстэй ажлыг ердийн дундаж ажилтан гүйцэтгэх хугацааг мөн үндэслэсэн болно.

Хүснэгт 4. Стандарт үйл ажиллагаанд зарцуулах нийт хугацаа

№	Үүргийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа
1.	Системд мэдээллийн аюулгүй байдлын аудит	Эрх авсан этгээдүүдийн талаар судлах	15 мин
2.	хийлгэж, үр дүнг олон нийтэд танилцуулах	Сонгосон аудитортай харилцах, санал тавих	30 мин
3.		Аудитын үйл ажиллагаанд бэлтгэх	480 мин
4.		Үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх	8 мин
5.	Нэмэлт хөгжүүлэлтийг үндсэн системд холбохоос өмнө	Эрх авсан этгээдүүдийн талаар судлах	15 мин

6.	кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх	Сонгосон байгууллагатай харилцах, санал тавих	30 мин
7.		Үнэлгээ хийлгэх үйл ажиллагаанд бэлтгэх	480 мин
8.		Үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх	8 мин
9.	Хүүхдэд хориглосон агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлах	Шийдлийг боловсруулах	480 мин
10.	технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйлчилгээг боловсруулах	480 мин
11.		Хэрэглэгчид боломжит хувилбараар мэдэгдэх	2 мин
12.	Хүүхдийн дугаар олгох;	Гаргасан хүсэлт, мэдээллийг нягтлах	15 мин
13.		Хэрэглэгчээр бүртгэх, хадгалах	5 мин
14.		Хэрэглэгчид үйлчилгээ авах эрх үүсгэх	2 мин
НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА			1580 мин

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа дундаж ажилтанд олгох сарын үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг ажилтны ажиллах цагийн горимоор тогтоосон хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргав.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд дундаж цалин 2.726,9 сая төгрөг байна.¹

Хүснэгт 5. Ажлын хөлс

Ажлын хөлс = Үндсэн цалинг : Ажиллах хугацаа
2,726,900 : 22 өдөр : 8 цаг=15,494 /дунджаар ажлын нэг цагт ноогдох хөдөлмөрийн хөлс/ 15,494:60 минут=258.2 төгрөг /нэг минутын хөдөлмөрийн хөлс/

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа:

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа захиргааны үйл ажиллагааны зардлыг ажлын хөлсөөр үржүүлж тодорхойлно.

Нэг хуулийн этгээдийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 1580 минут буюу 26.33 цагийг зарцуулахаар байна.

Хүснэгт 6. Нэг хуулийн этгээдэд гарах үйл ажиллагааны зардал

Зардал (ҮА тус бүрийн) = Хугацаа * Ажлын хөлс
--

407,957= 26.33 * 15,494

№	Үүргийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Нэг минутын хөдөлмөрийн хөлс	Зардал /ҮА тус бүрээр/
1.	Системд мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэж, үр дүнг олон нийтэд танилцуулах	Эрх авсан этгээдүүдийн талаар судлах	15 мин	258.2	3,873
2.		Сонгосон аудитортой харилцах, санал тавих	30 мин	258.2	7,746
3.		Аудитын үйл ажиллагаанд бэлтгэх	480 мин	258.2	123,936
4.		Үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх	8 мин	258.2	2,065.6
5.	Нэмэлт хөгжүүлэлтийг үндсэн системд холбохоос өмнө кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх	Эрх авсан этгээдүүдийн талаар судлах	15 мин	258.2	3,873
6.		Сонгосон байгууллагатай харилцах, санал тавих	30 мин	258.2	7,746
7.		Үнэлгээ хийлгэх үйл ажиллагаанд бэлтгэх	480 мин	258.2	123,936
8.		Үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх	8 мин	258.2	2,065.6
9.	Хүүхдэд хориглосон агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлах технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Шийдлийг боловсруулах	480 мин	258.2	123,936
10.		Үйлчилгээг боловсруулах	480 мин	258.2	2,582
11.		Хэрэглэгчид боломжит хувилбараар мэдэгдэх	2 мин	258.2	516.4

12.	Хүүхдийн дугаар олгох;	Гаргасан хүсэлт, мэдээллийг нягтлах	15 мин	258.2	3,873
13.		Хэрэглэгчээр бүртгэх, хадгалах	5 мин	258.2	1,291
14.		Хэрэглэгчид үйлчилгээ авах эрх үүсгэх	2 мин	258.2	516.4
НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА			1580 мин		407,956

Хуулийн этгээдийн цахим системд зориулсан нас баталгаажуулах систем нь төрийн худалдан авах ажиллагааны хамрах хүрээнд ордоггүй тул tender.gov.mn-д ийм тендер бүртгэгдэхгүй бөгөөд тус системийг жишиг үнийн эх сурвалж болгон ашиглах боломжгүй байна. Монголын зах зээлийн хөгжүүлэлтийн үнэлгээнд үндэслэхэд хувийн хэвшлийн платформд зориулсан насны баталгаажуулалтын системийн зардал нь хэрэгжүүлэх хувилбараас хамааран ялгаатай байдаг бөгөөд тусдаа модуль хөгжүүлэлт 30-150 сая төгрөг байж болохоор байна. Иймд хэрэглэгчийн нас баталгаажуулах систем хөгжүүлэлтийн дундаж зардал 90 сая төгрөг гэж тооцсон.

Нэг хуулийн этгээдийн үйл ажиллагааны захиргааны зардал 90,407,956 төгрөг байхаар байна.

3.3.Тоон үзүүлэлтийг тооцох

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар бий болох үүргийг хэдэн хуулийн этгээд, жилд хэдэн удаа гүйцэтгэхийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргана. Энэ үзүүлэлтийг гаргахын тулд тохиолдлын тоо болон давтамжийг холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдээнээс үзэхэд үүрэн холбооны чиглэлээр үйлчилгээ эрхэлж буй 5 хуулийн этгээд байна. Мөн хуулийн үйлчлэлд хамаарах хүүхдийн тоо 270,464 байна.

Харин интернэтийн үйлчилгээ эрхлэхээр харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын дагуу хуулийн төслийн 12 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа тул нэмэлтээр зардал үүсэхээргүй байна.

Хүснэгт 7 . Хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийн тоон үзүүлэлт

№	Үүргийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
1.	Системд мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэж, үр дүнг олон нийтэд танилцуулах	Эрх авсан этгээдүүдийн талаар судлах	5	1	5
2.		Сонгосон аудитортой харилцах, санал тавих	5	1	5
3.		Аудитын үйл ажиллагаанд бэлтгэх	5	1	5
4.		Үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх	5	1	5
5.	Нэмэлт хөгжүүлэлтийг үндсэн системд холбохоос өмнө кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх	Эрх авсан этгээдүүдийн талаар судлах	5	1	5
6.		Сонгосон байгууллагатай харилцах, санал тавих	5	1	5
7.		Үнэлгээ хийлгэх үйл ажиллагаанд бэлтгэх	5	1	5
8.		Үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх	5	1	5
9.	Хүүхдэд хориглосон агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлах технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Шийдлийг боловсруулах	5	1	5
10.		Үйлчилгээг боловсруулах	5	1	5
11.		Хэрэглэгчид боломжит хувилбараар мэдэгдэх	5	1	5
12.	Хүүхдийн дугаар олгох;	Гаргасан хүсэлт, мэдээллийг нягтлах	270,464	1	270,464
13.		Хэрэглэгчээр бүртгэх, хадгалах	270,464	1	270,464

14.		Хэрэглэгчид үйлчилгээ авах эрх үүсгэх	270,464	1	270,464
-----	--	---------------------------------------	---------	---	---------

3.4. Нийт зардлын мөнгөн дүнг тооцож гаргах

Хуулийн төслийн дагуу шинээр хүлээсэн үүргийг хуулийн төслийн үйлчлэлд хамаарах нийт хуулийн этгээдэд ямар хэмжээний зардал гарахнэг бүрийн зардлыг “тоон үзүүлэлт”-ээр үржүүлж тооцно.

Хүснэгт 8. Хуулийн этгээдийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдэд хууль хэрэгжүүлэхэд гарах нийт зардал

№	Үүргийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зардал	Тоон үзүүлэлт	Нийт зардал
1.	Системд мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэж, үр дүнг олон нийтэд танилцуулах	Эрх авсан этгээдүүдийн талаар судлах	3873	5	19,365
2.		Сонгосон аудитортай харилцах, санал тавих	7746	5	38,730
3.		Аудитын үйл ажиллагаанд бэлтгэх	123936	5	619,680
4.		Үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх	2065.6	5	10,328
5.	Нэмэлт хөгжүүлэлтийг үндсэн системд холбохоос өмнө кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх	Эрх авсан этгээдүүдийн талаар судлах	3873	5	19,365
6.		Сонгосон байгууллагатай харилцах, санал тавих	7746	5	38,730
7.		Үнэлгээ хийлгэх үйл ажиллагаанд бэлтгэх	123936	5	619,680
8.		Үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх	2065.6	5	10,328

9.	Хүүхдэд хориглосон агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлах технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Шийдлийг боловсруулах	123936	5	619,680
10.		Үйлчилгээг боловсруулах	2582	5	12,910
11.		Хэрэглэгчид боломжит хувилбараар мэдэгдэх	516.4	5	2,582
12.	Хүүхдийн дугаар олгох;	Гаргасан хүсэлт, мэдээллийг нягтлах	3873	270,464	1,047,507,072
13.		Хэрэглэгчээр бүртгэх, хадгалах	1291	270,464	349,169,024
14.		Хэрэглэгчид үйлчилгээ авах эрх үүсгэх	516.4	270,464	139,667,609.6
Нийт дүн			407956		1,538,355,084

Хуулийн төслийн үйлчиллэлд хамаарах нийт хуулийн этгээдэд үүсэх зардал нь 1,538,355,084 төгрөг, хэрэглэгчийн нас баталгаажуулах дундын систем хөгжүүлэлт 90,000,000 төгрөг болохоор байна.

3.5. Хялбарчлах боломж байгаа эсэхийг тогтоох

Хүснэгт 9. Үүргийг хялбарчлах боломж

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар
1.	Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх	Боломжгүй	Хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийг статистикаас барагцаалж буюу нийт 5 хуулийн этгээд байна гэж үзсэн ба энэ тоо нь цаашид нэмэгдэх магадлалтай гэж харж байна
2.	мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;	Боломжгүй	Энэ чиглэлийн үүрэг тусгагдаагүй
3.	мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;	Боломжгүй	Энэ чиглэлийн үүрэг тусгагдаагүй

4.	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх	Боломжтой	Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо бүх түвшинд хангагдаж байж хууль хэрэгжих боломжтой болно. Харин хуулийн этгээдүүд нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Кибер аюулгүй байдлын тухай хуулиар мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хоёр жил тутамд, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг жил тутам хийлгэхээр заасан тул эдгээр үүргүүдийг нэгтгэх боломжтой буюу энэ төрлийн зардал нэмэлтээр гарахгүй байх боломжтой.
5.	мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;	Боломжтой	Энэ чиглэлийн үүрэг тусгагдаагүй
6.	мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;	Боломжтой	Энэ чиглэлийн үүрэг тусгагдаагүй
7.	нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх гэх мэт.	Боломжтой	Энэ чиглэлийн үүрэг тусгагдаагүй

3.6.Нэмэлт зардал

Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээдийн зүгээс хуульд заасан үүргийг биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хууль тогтоомжоор тогтоосон төлбөр хураамж, шинээр худалдан авах шаардлагатай тоног төхөөрөмж, материал зэрэгтэй холбогдон үүсч, шууд гарах зардлыг нэмэлт зардал гэсэн ойлголтод хамруулж тооцсон болно.

Хүснэгт 10.Нэмэлт зардлын тооцоо /төгрөгөөр/

Үүргийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Үнийн дүн (төгрөг)
Үйлдлийн бүртгэлийг хадгалах сервер, тоног төхөөрөмж бэлтгэх	Иж бүрэн тоног төхөөрөмж худалдан авах	127,160,000

3.7.Дүгнэлт

Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдэд жилд 1,628,355,084 төгрөгийн захиргааны зардал, шинээр тоног төхөөрөмж худалдан авах бол 127,160,000 төгрөгийн нэмэлт зардал гарахаар тооцсон бөгөөд 1 хуулийн этгээдэд 351,103,016.8 төгрөгийн захиргааны зардлын ачаалал үүсэхээр байна. Гэвч

хүүхдийн дугаар олголт нь нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа тул дараагийн жилээс хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлаас 1,536,343,706 хүртэлх төгрөг буурна. Түүнчлэн хуулийн этгээд нь үйлчилгээ үзүүлсний төлбөрт жилд 12,170,880,000 төгрөгийн үйлчилгээний хөлс авахаар байна. Мөн систем хөгжүүлэлт нь нэг удаагийн шинжтэй тул хөгжүүлэлтийн зардал буурах ч ашиглалт үйлчилгээний зардал гарахаар байна.

ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ

4.1 Төрийн байгууллагын чиг, үүргийг тодорхойлох

Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төслийн 4 дүгээр бүлэг “Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах талаар төрийн байгууллагын чиг үүрэг”-т төрийн байгууллагын зүгээс нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах нарийвчилсан чиг үүргийн зохицуулалтууд туссан. Төрийн захиргааны байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагын төсөвт хэдий хэр ачаалал, зардал үүсэх магадлалтайг баримжаалан тооцоолно. Төрийн захиргааны байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хуулийн зохицуулалтын хэрэгжих боломжийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- Гарах зардлыг урьдчилан тооцоолох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Аргачлалын дагуу хуулийн төсөлд төрийн холбогдох байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүрэг /ажил, үйлчилгээ/, тухайг чиг үүргийг гүйцэтгэх байгууллага, төсвөөс гарах зардалтай холбоотой зүйл, заалтыг түүвэрлэн Хүснэгт 11-т харуулав.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төсөлд тусгагдсан төрийн зүгээс авч хэрэгжүүлэх чиг үүргийн дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна. Үүнд:

1. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
5. Харилцаа холбооны зохицуулах хороо
6. Хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төв

Байгууллагыг сонгохдоо Аргачлалын 4.3.2-т “байгууллагыг сонгохдоо тухайг ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгоно” гэж заасны дагуу голлох үүрэг гүйцэтгэх төрийн байгууллагуудыг сонгосон.

Хүснэгт 11.Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төсөлд төрийн байгууллагын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх байгууллагууд

№	Хуулийн зүйл, заалт	Үүргийн мэдээлэл	Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага
1.	Хуулийн төслийн 14.1.1.нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах асуудлаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11-д “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” Энэ журмаар Хүүхэд хамгааллын тухай хууль /цаашид "Хууль" гэх/-ийн 4.1.15, 4.1.16-д заасан хүүхдийг хориотой ^[1] болон хүүхдэд хортой ^[2] агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой оролцогч талуудын үйл ажиллагааг зохицуулна. гэж заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.

2.	Хуулийн төслийн 14.1.2.нийгмийн сүлжээний болон харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчийг энэ хуульд заасан үүргээ биелүүлэхэд хамтран ажиллах;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.12-д “Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана.” гэж заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
3.	Хуулийн төслийн 14.1.3.нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ, хэлцлийн түвшинд хамтран ажиллах;	Үүрэгжүүлсэн заалт	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4.	Хуулийн төслийн 7.4.Энэ хуулийн 7.3-т заасан үнэлгээнд үндэслэн зохицуулалттай нийгмийн сүлжээний үйлчилгээний жагсаалтыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийтэд мэдээлнэ.	Үүрэгжүүлсэн заалт	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.	Хуулийн төслийн 7.2.Нийгмийн сүлжээний үйлчилгээний эрсдэлийг үнэлэх журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Үүрэгжүүлсэн заалт	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6.	Хуулийн төслийн 15.1.1.боловсролын байгууллага, сургуулийн орчинд нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1-д “боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах” гэж заасны дагуу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

			байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
7.	Хуулийн төслийн 15.1.2.сургалтын хөтөлбөрт нийгмийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах агуулгыг үе шаттайгаар тусгах;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.3-д “боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн сургалтын хөтөлбөрт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэх агуулга туссан эсэхэд хяналт тавих.” гэж заасны дагуу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
8.	Хуулийн төслийн 15.1.3.сургуулийн орчинд зөвшөөрөгдсөнөөс бусад нийгмийн сүлжээний хэрэглээг хязгаарлах ажлыг зохион байгуулах;	Үүрэгжүүлсэн заалт	Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмын 2.5.2-д “сургуулийн болон дотуур байрын орчинд ашиглаж буй интернэтийг 18+ контентын шүүлтүүртэй байхаар интернэтийн үйлчилгээ эрхлэгч ^[4] -тэй байгуулах гэрээнд тусгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих”, 2.5.4-д “өөрийн үйл ажиллагаанд мөрдөх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахтай холбоотой дүрэм, журамд сургуулийн орчинд интернэтийн хэрэглээнд хяналт тавих зохицуулалтыг тусгаж, мөрдүүлэх” гэж заасны дагуу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
9.	Хуулийн төслийн 115.1.4.сургалтын үйл ажиллагаа, суралцагчтай холбоотой мэдээлэл солилцох зориулалтын программ хангамж нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;	Үүрэгжүүлсэн заалт	Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмын 2.5.6-д “багш, ажилтан боловсролын сургалтын үйл ажиллагаанд хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах, мэдээлэл солилцох, хамтран ажиллахдаа цахим

			орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангасан платформыг ашиглана.” гэж заасны дагуу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
10.	Хуулийн төслийн 16.1.1.нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах талаарх хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд заасан зорилго, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд үндэслэн явцын болон эцсийн үнэлгээг хийнэ. Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг үнэлгээнд тусгана.” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
11.	Хуулийн төслийн 16.1.2.холбогдох төрийн байгууллагатай хамтран нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтэд чиглэсэн мэдлэг олгох, соён гэрээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11-д “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” Энэ журмаар Хүүхэд хамгааллын тухай хууль /цаашид "Хууль" гэх/-ийн 4.1.15, 4.1.16-д заасан хүүхдийг хориотой ^[1] болон хүүхдэд хортой ^[2] агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой оролцогч талуудын үйл ажиллагааг зохицуулна. гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.

12.	Хуулийн төслийн 16.1.4. нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах салбар дундын зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.12-д “Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана.” гэж заасан. Тус зөвлөлийн үйл ажиллагааг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллана.
13.	Хуулийн төслийн 16.1.5.нийгмийн сүлжээнээс үүдэлтэй эрсдэлийг судалж, хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл бүхий зохисгүй агуулгад дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг хүүхэд, гэр бүлийн, цахим хөгжил, харилцаа холбооны, хууль зүйн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.12-д “Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана.” гэж заасан. Тус зөвлөлийн үйл ажиллагааг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллана.
14.	Хуулийн төслийн 16.1.6. нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээний стандартыг боловсруулж, Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар батлуулах	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллана.
15.	Хуулийн төслийн 17.1.1.хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, олон	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22.2-д “Эцэг, эх хүүхдийн эрхийг

	нийт, мэргэжилтэнд зориулсан хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цахим ур чадвар олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;		хамгаалах, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авна.” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
16.	Хуулийн төслийн 17.1.2.хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зориулсан нийгмийн сүлжээний эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22.2-д “Эцэг, эх хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авна.” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
17.	Хуулийн төслийн 17.1.3.хүүхэд залуучуудын оролцооны байгууллага, хуулийн этгээд болон иргэд, олон нийтийн оролцоог хангаж, хамтран ажиллах;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22.2-д “Эцэг, эх хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авна.” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ
19.	Хуулийн төслийн 17.1.4.хүүхдийн эрхийн улсын байцаагчид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-д “Хүн, хуулийн этгээд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд хориотой агуулга түгээснээс хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзвэл гомдлоо хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагад гаргаж, шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.

18	Хуулийн төслийн 17.1.6.нийгмийн сүлжээнд эрх, ашиг нь хөндөгдөж, хохирсон хүүхдэд Хүүхэд хамгааллын тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт заасны дагуу үйлчилгээ үзүүлэх;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн “Хоёрдугаар бүлэгт заасны дагуу үйлчилгээ үзүүлнэ.” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
19	Хуулийн төслийн 17.1.6.нийгмийн сүлжээнд эрх, ашиг нь хөндөгдөж, хохирсон хүүхдэд Хүүхэд хамгааллын тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт заасны дагуу үйлчилгээ үзүүлнэ.	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн “Хоёрдугаар бүлэгт заасны дагуу үйлчилгээ үзүүлнэ.” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
20	Хуулийн төслийн 7.3.Энэ хуулийн 7.2-т заасан журмын дагуу Монгол улсаас 175,000-аас дээш хэрэглэгчтэй нийгмийн сүлжээний үйлчилгээнд, эсхүл иргэдийн гомдол, мэдээлэлд үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо эрсдэлийн үнэлгээ хийнэ.	Үүрэгжүүлсэн заалт	Харилцаа холбооны зохицуулах хороо
21	Хуулийн төслийн 18.1.1. нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуулийн 6.3, 11.1.5-д заасан үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2–д “Хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, хүүхдэд хортой агуулга, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд түгээх, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
22	Хуулийн төслийн 18.1.2.нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч энэ хуулийн	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2–д “Хүүхдийн эрүүл мэнд, бие

	11 дүгээр зүйлд заасан үүргээ биелүүлээгүй тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх;		махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, хүүхдэд хортой агуулга, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд түгээх, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
23	Хуулийн төслийн 18.1.3. эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийн талаарх мэдээллийг нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй хүргүүлэх.	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д “Хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, хүүхдэд хортой агуулга, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд түгээх, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
24	Хуулийн төслийн 16.1.1.нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах талаарх хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд заасан зорилго, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд үндэслэн явцын болон эцсийн үнэлгээг хийнэ. Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан

			дэмжигчийн саналыг үнэлгээнд тусгана.” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ.
25.	Хуулийн төслийн 19.1.1.энэ хуулийн үйлчлэлд хамаарах аливаа үйл ажиллагаа, хүүхдийн эрх, аюулгүй байдлын зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, хүсэлтийг хүн, хуулийн этгээдээс хүлээн авч бүртгэх, холбогдох төрийн эрх бүхий байгууллагад шилжүүлэх, холбон зуучлах;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төв
26.	Хуулийн төслийн 19.1.2.гомдол, мэдээллийн дагуу авсан арга хэмжээний талаарх тайланг харьяа дээд байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллагад улирал бүр мэдээлэх;	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төв
27.	Хуулийн төслийн 19.1.3.энэ зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан олон нийтийг мэдээ, мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах.	Үүрэгжүүлсэн заалт	Хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төв

Хүснэгт 12. Төрийн байгууллагын зардлыг тодорхойлсон байдал

№	Хуулийн зүйл, заалт	Үүргийн мэдээлэл	Хугацаа /Цаг/
1	Хуулийн төслийн 14.1.1.нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах асуудлаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Хуулийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийн ажлыг үе шаттай зохион байгуулах;	-
2	Хуулийн төслийн 14.1.2.нийгмийн сүлжээний болон харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчийг энэ хуульд заасан үүргээ биелүүлэхэд хамтран ажиллах;	Хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	-

3	Хуулийн төслийн 14.1.3.нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ, хэлцлийн түвшинд хамтран ажиллах;	Хамтын ажиллагааны гэрээ, хэлцэл хийх, санамж бичиг байгуулах	-
4	Хуулийн төслийн 7.4.Энэ хуулийн 7.3-т заасан үнэлгээнд үндэслэн зохицуулалттай нийгмийн сүлжээний үйлчилгээний жагсаалтыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийтэд мэдээлнэ.	Нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн ангиллын жагсаалтыг тухай бүр олон нийтэд мэдээлэх	-
5	Хуулийн төслийн 15.1.1.боловсролын байгууллага, сургуулийн орчинд нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих	Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;	-
6	Хуулийн төслийн 15.1.2.сургалтын хөтөлбөрт нийгмийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах агуулгыг үе шаттайгаар тусгах;	Сургалтын хөтөлбөрт цахим ур чадварын боловсролын агуулгыг үе шаттайгаар нэвтрүүлэх, тусгах;	-
7	Хуулийн төслийн 15.1.3.сургуулийн орчинд зөвшөөрөгдсөнөөс бусад нийгмийн сүлжээний хэрэглээг хязгаарлах ажлыг зохион байгуулах;	Нийслэл,хөдөө орон нутгийн сургууль, дотуур байрны орчинд нийгмийн сүлжээний хэрэглээг хязгаарлах	-
8	Хуулийн төслийн 15.1.4.сургалтын үйл ажиллагаа, суралцагчтай холбоотой мэдээлэл солилцох зориулалтын программ хангамж нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;	Мэдээлэл солилцох зориулалтын программ хангамж нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;	-
9	Хуулийн төслийн 16.1.1.нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах талаарх хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах талаарх хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	-
10	Хуулийн төслийн 16.1.2.холбогдох төрийн байгууллагатай хамтран нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтэд чиглэсэн мэдлэг олгох,	Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зориулсан зөвлөмж боловсруулах, соён гэрээрүүлэх үйл	-

	соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;	ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;	
11	Хуулийн төслийн 16.1.4.нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах салбар дундын зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;	Зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх,	-
12	Хуулийн төслийн 16.1.5.нийгмийн сүлжээнээс үүдэлтэй эрсдэлийг судалж, хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл бүхий зөрчилтэй агуулгад дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг хүүхэд, гэр бүлийн, цахим хөгжил, харилцаа холбооны, хууль зүйн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах;	Нийгмийн сүлжээнээс үүдэлтэй Эрсдэлийн судалгаа хийх; Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах;	-
13	Хуулийн төслийн 16.1.6. нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээний стандартыг боловсруулж, Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар батлуулах.	Хүүхдийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээний стандартыг боловсруулж, Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар батлуулах.	-
14	Хуулийн төслийн 17.1.1.хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, олон нийт, мэргэжилтэнд зориулсан хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цахим ур чадвар олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Цахим ур чадвар олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	-
15	Хуулийн төслийн 17.1.2.хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зориулсан нийгмийн сүлжээний эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;	нийгмийн сүлжээний эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;	-

16	Хуулийн төслийн 17.1.4.хүүхдийн эрхийн улсын байцаагчид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах;	хүүхдийн эрхийн улсын байцаагчид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах;	-
17	Хуулийн төслийн 17.1.6.нийгмийн сүлжээнд эрх, ашиг нь хөндөгдөж, хохирсон хүүхдэд Хүүхэд хамгааллын тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт заасны дагуу үйлчилгээ үзүүлнэ.	Гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх, холбон зуучлах;	-
18	Хуулийн төслийн 17.1.2.нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч нь хуульд заасан шаардлагыг хангаж буй эсэхэд хяналт тавих;	Хэрэгжилтэд хяналт тавих;	-
19	Хуулийн төслийн 17.1.3.хүүхэд залуучуудын оролцооны байгууллага, хуулийн этгээд болон иргэд, олон нийтийн оролцоог хангаж, хамтран ажиллах;	Хүүхэд залуучуудын оролцооны байгууллага, хуулийн этгээд болон иргэд, олон нийтийн оролцоог хангаж, хамтран ажиллах;	-
20	Хуулийн төслийн 18.1.1. нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуулийн 6.3, 11.1.5-д заасан үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих;	хяналт тавих;	-

Хуулийн төслийн хүрээнд одоо байгаа чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжтой бөгөөд тухайн төрийн байгууллагад нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж, албан тушаалын орон тоог шинээр бий болгох зардал үүсэх боловч батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэгдэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

4.2 Гаргах зардлыг тооцох

Засгийн газрийн бүрэн эрх: Хүүхдийн эрх хамгааллын талаар урт болон дунд хугацааны бодлого, стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, салбар хоорондын уялдааг хангах эрх зүйн хэм хэмжээний актыг батлах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх тул шинээр орон тоо нэмэх, бүтэц өөрчлөх шаардлагагүй тул төсөвт ямар нэгэн зардал нэмэгдэхээргүй байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх: Хуулийн төсөлд туссан чиг үүрэгүүд нь нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, нийгмийн сүлжээний болон харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчийг энэ хуульд заасан

үүргээ биелүүлэхэд хамтран ажиллах зэрэг нарийвчилсан харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл Хэвлэл мэдээлэл, Өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргүүд байгаа тул Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны батлагдсан орон тооныхоо хүрээнд хэрэгжилтийг хангах боломжтой тул улсын төсөвт нэмэлт зардал шаардахгүй.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх: Хуулийн төсөлд туссан чиг үүргүүд нь нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар сургалтын хөтөлбөрт нийгмийн сүлжээн дэх аюулгүй байдал, дижитал боловсролын агуулгыг үе шаттайгаар тусгах, сургуулийн орчинд сургалтын үйл ажиллагаа, даалгавар, үнэлгээ, сурагчтай холбоотой мэдээлэл солилцох болон албан харилцаанд ашиглах зөвшөөргдөх программ хангамжийн шаардлага боловсруулж, нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, суралцагчдад нийгмийн сүлжээний аюулгүй хэрэглээ, эрсдэлийн талаарх мэдлэг, ур чадвар олгох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах асуудлуудыг нарийвчлан хуульчилж өгсөн.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11-д “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу 2025 онд тус журмыг баталсан бөгөөд тус журмын 2.5.2-д “сургуулийн болон дотуур байрын орчинд ашиглаж буй интернэтийг 18+ контентын шүүлтүүртэй байхаар интернэтийн үйлчилгээ эрхлэгчтэй байгуулах гэрээнд тусгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;” гэж, 2.5.4-д “өөрийн үйл ажиллагаанд мөрдөх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахтай холбоотой дүрэм, журамд сургуулийн орчинд интернэтийн хэрэглээнд хяналт тавих зохицуулалтыг тусгаж, мөрдүүлэх” тус тус заасан байдаг.

Хуулиар ногдуулсан чиг үүргийн хүрээнд илүү тодорхой зохицуулалтыг хуульчилсан бөгөөд Боловсролын яам батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд хэрэгжилтийг хангах боломжтой, нэмэлт үүрэг ногдуулж, зардал нэмэгдэхгүй зохицуулалтууд тул улсын төсөвт нэмэлт зардал үүсэхээргүй байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх: Хуулийн төсөлд нийгмийн сүлжээнд Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар олон нийтэд чиглэсэн сургалт, судалгааны ажил эрхлэх асуудлуудын хэрэгжилтийг хангахтай холбоотой эрх үүргийг нарийвчлсан зохицуулалтыг тусгасан тул одоогын хэрэгжүүлж буй чиг үүрэг, хүний нөөцийн боломжиндоо хэрэгжилтийг хангах боломжтой, нэмэлт зардал гарахгүй.

Харилцаа холбооны зохицуулах хороо: Харилцаа холбооны зохицуулах хороо нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл “Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал”-д заасны дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Internet Watch Foundation report system (IWF)

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран IWF-ийн хүүхдийн бэлгийн хүчирхийллийн зураг, видеог мэдээлж, хязгаарлалт хийх боломж бүрдүүлсэн. IWF портал сайтыг www.ekids.mn сайтын нэмэлт хэлбэрээр 2020 оны 6 дугаар сараас эхлэн нэвтрүүлсэн ба тус системд Монгол, Казак болон Англи хэлээр хүсэлт явуулах боломжтой. IWF репортын системээр дамжуулан хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашигласан видео, зураг материалыг интернэт орчноос арилгах, устгах, хэрэглэгчийг илрүүлэх ажлыг хийж байна.

НҮБ-ын хүүхдийн сантай хамтран IWF-ийн портал сайтыг ekids.mn сайтын нэмэлт хэлбэрээр нэвтрүүлсэн. IWF-д 2020-2026 оны 1-р улирлын байдлаар нийт 300 репорт хийсэн.

2. Government case work channel

2019 оны 10 дугаар сараас эхлэн Фэйсбүүк компанитай хамтран “Засгийн газартай хамтран ажиллах суваг (Government case work channel)” буюу ногоон сувгийг байгуулан ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийн дагуу хууль бус контент хязгаарлах, устгах талаарх хүсэлтийг Мета компанид нэн даруй хүргүүлдэг. */Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1-90 хоног/*

3. <http://black-list.mn/>

Харилцаа холбооны зохицуулах хороо хүүхдийн хөгжилд сөрөг нөлөөтэй, хууль бус контентын зохицуулалтын талаар Үүрэн холбооны болон Интернэтийн үйлчилгээ эрхлэгчидтэй 2013 оноос хойш хамтран ажиллаж байна. Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн утга агуулгатай контентыг нийтэлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтээр веб сайтыг хар жагсаалтад оруулж DNS системийн бүртгэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрээс хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авдаг.

4. YouTube trusted partner

Харилцаа холбооны зохицуулах хороо 2021 оны 5 дугаар сараас эхлэн “YouTube” платформтой хамтран ажиллаж хууль бус контентыг “trusted partner” горимоор мэдээлж байна.

5. Тикток

Tik Tok платформтой 2025 оноос хамтын ажиллагааг эхлүүлэн, хүүхэд хамгаалал, зөрчилтэй контентын асуудлаар Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран ажиллаж байна.

6. “X trusted flagger”


ХХЗХороо 2024 оны 6 дугаар сараас “X” платформтой хамтран твиттерийн үйл ажиллагааны дүрэм, үйлчилгээний нөхцөлийг зөрчсөн контентыг мэдээлэх сувгийг үүсгэж, хамтран ажиллаж эхэлсэн. Хуулийн төсөлд Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх үүрэгт дээрх технологийн арга хэмжээг нарийвлан тусгасан зохицуулалтууд орсон тул нэмэлт төсөв шаардахгүй.

Хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төвийн чиг үүрэг: Хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төвийн хувьд цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаарх дуудлага, мэдээллийг Хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарт хүлээн авч холбон зуучилж, зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилладаг. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026.04.22 хүртэл нийт 535.197 дуудлага мэдээлэл хүлээж авсан. Үүнээс хүүхэд хамгааллын дуудлага 79.162 үүнээс цахим дарамттай холбоотой дуудлага мэдээлэл 1.024 бүртгэгдсэн байна.

Цахим дарамттай холбоотой дуудлага мэдээлэл нь нийт хүүхэд хамгааллын дуудлагын 1.2 хувийг эзэлж байна. Нийт 1024 дуудлага ирснээс утсаар-376, фэйсбүүк чатаар-634, мессежээр-13, цахим шуудангаар-1 мэдээлэл ирүүлсэн байна.

Хүснэгт 13. дуудлагын тоон мэдээлэл

№	Он	Нийт	Хүүхэд хамгааллын үйлчилгээнд Шилжүүлсэн	Хамтарсан баг ажиллаж дууссан	Зөвлөгөө өгч дуусгасан
1	2021	58	23	11	47
2	2022	167	47	40	125
3	2023	530	44	41	488
4	2024	96	42	42	54
5	2025	129	71	65	61
6	2026.04.22	44	24	13	20
Нийт		1024	251	212	795



Дээрх мэдээллээс харахад нийт цахим дарамттай холбоотой дуудлага мэдээллийн 251 буюу 24.5%-ийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд холбон зуучилсан бөгөөд 84.4%-д хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Хүснэгт 14. Цахим дарамттай холбоотой дээрх дуудлага мэдээллийн ангилал:

№	Он	Нэр төрд халдах	Утсаар дарамтлах айлган сүрдүүлэх	Зураг бичлэгээр сүрдүүлэх, дарамтлах	Бусад
1	2021	58	0	0	0
2	2022	51	30	62	24
3	2023	334	51	87	56
4	2024	25	13	48	7
5	2025	56	9	57	7
6	2026.04.22	29	3	12	0
Нийт		553	106	266	94

Хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төвд бүртгэгдсэн нийт дуудлага мэдээллээс чат, мессежээр ирүүлсэн тоог харьцуулбал:

Хүснэгт 15. Дуудлага ирсэн сувгаар

	2021	2022	2023	2024	2025	2026.04.22	Нийт
Нийт дуудлага	99306	111807	111272	101311	88164	23337	535197
Чат	528	1865	3036	1318	1124	402	8273

Хүүхдийг цахимаар дээрэлхсэн, дарамталсан харилцаатай холбоотой дуудлага 2021-2026 онд нийт 221 удаа ирсэн бөгөөд, ирүүлсэн гомдол, мэдээллийг

Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст тухай бүр цахим шуудангаар илгээж, цагдаагийн байгууллагын хяналтад шилжүүлсэн байна.

Засгийн газрын 2025 оны 209 дүгээр тогтоол, ГБХНХЯ-ны сайдын 2026 оны А/14 дүгээр тушаал, ХГБХХЕГ-н даргын А/07 дугаар тушаалаар Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байрыг нэгтгэн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын дэргэдэх “108 хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төв”-ийг байгуулж, бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Тус төв нь захиргаа хүний нөөцийн алба, дуудлага мэдээлэл шуурхай тусламжийн үйлчилгээний алба, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний алба гэсэн 3 албаар дамжуулан нийт 43 ажилтан, албан хаагчийн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. 108 тусгай дугаар нь одоогын байдлаар дуудлага хүлээн авдаг 4 шугамтай ба 4 ээлжээр буюу 24/72 хуваарьтай 16 оператор ажиллаж байна.

Хуулиар ногдуулсан чиг үүргийн хүрээнд илүү тодорхой зохицуулалтыг хуульчилсан бөгөөд тус хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх зорилготой тул одоо байгаа байгууллагын батлагдсан орон тооны хүрээнд хэрэгжилтийг хангах боломжтой нэмэлт үүрэг ногдуулж, зардал үүсгэхгүй зохицуулалтууд тул улсын төсийн хүрээнд шийдвэрлэх боломжтой байна.

4.3. Хувилбарыг нягталж зардлыг буулах боломжийг эрэлхийлэх

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д “Төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүүхэд хамгааллыг дэмжих, хэрэгжүүлэх үүрэгтэй.” гэж, мөн хуулийн 52 дугаар зүйлийн 52.6-д “Засгийн газрын гишүүд эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээ, энэ хуулийн 30.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээ авна.” гэж тус тус заасан бөгөөд Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд тусгасан хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүргийг илүү тодорхой болгож, нарийвчлан зохицуулж өгсөн тул төрийн байгууллагад нэмэлт үүрэг ногдуулж, зардал үүсгэхгүй зохицуулалтууд байна.

Улсын төсвөөс гарах санхүүжилт нь тухайн жилийн улсын төсөвт нэмэлт зардал болохгүй бөгөөд Засгийн газрын гишүүд эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулахаар байна.

Хүний нөөцийн хувьд төрийн байгууллагуудад хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг хариуцсан нэгж, газар хэлтэс, албатай болно.

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд заасны дагуу хэмжигдэхүйц зардлыг тооцсон болно. Үүнд:

1.Хуулийн төсөлд туссан заалтыг хэрэгжүүлэхэд иргэнээс гарах зардал 60,000 - 70,000 төгрөг байна.

2. Хуулийн төсөлд тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдэд жилд 1,628,355,084 төгрөгийн захиргааны зардал, 127,160,000 төгрөгийн нэмэлт зардал гарахаар тооцсон бөгөөд нийт зардал 1,755,515,084 төгрөг, 1 хуулийн этгээдэд 351,103,016.8 төгрөгийн захиргааны үйл ажиллагааны зардал үүснэ. Гэвч хүүхдийн дугаар олголт нь нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа тул дараагийн жилээс хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал 1,536,343,706 хүртэлх төгрөгөөр буурах боломжтой.

3. Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллага болох Засгийн газар, Харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, Хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төвийн хүлээж буй үүргийг тусгасан. Энэхүү хуулийн төсөлд заасан үүргийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад нэмэлт зардал үүсгэхээргүй байна.

Мөн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр бичиг хэрэг, тээвэр шатахуун хангамжийн материалын зардлыг бууруулж, хэмнэх боломжтой байна

i

https://www.nso.mn/mn/statcate/tableview/Labour,%20business/Wages/DT_NSO_0400_025V1.px?subtables=MONTHLY%20AVERAGE%20NOMINAL%20WAGES,%20by%20occupation%20and%20gender